

“ИЛЧИТ МЕТАЛЛ” ХХК

**БУЛГАН АЙМГИЙН САЙХАН СУМЫН НУТАГТ
ОРШИХ ЭРЭЭНИЙ НҮҮРСНИЙ УУРХАЙН 2023 ОНД
ХЭРЭГЖҮҮЛЭХ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН
ТӨЛӨВЛӨГӨӨ**

/MV-014228, РД: 2784041/

УЛААНБААТАР ХОТ

2023 ОН

БАТЛАВ: БОАЖЯ-НЫ

ХБОБНУГ-ЫН ДАРГАА.ЭНХБАТ

ЗӨВШӨӨРЧ, ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮҮРЭГ ХҮЛЭЭСЭН:

“ИЛЧИТ МЕТАЛЛ” ХХК-ИЙН

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛН.БАТСУУРЬ

**БУЛГАН АЙМГИЙН САЙХАН СУМЫН НУТАГТ ОРШИХ
ЭРЭЭНИЙ НҮҮРСНИЙ УУРХАЙН 2023 ОНД ХЭРЭГЖҮҮЛЭХ
БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ
/MV-014228, РД: 2784041/**

ХЯНАСАН:

БОАЖЯ-НЫ ХБОБНУГ-ЫН

МЭРГЭЖИЛТЭН..... /Ц.ЖАРГАЛНЭМЭХ /

БОЛОВСРУУЛСАН:

“ИЛЧИТ МЕТАЛЛ” ХХК-ИЙН

БАЙГАЛЬ ОРЧНЫ МЭРГЭЖИЛТЭН...../Н.ГЭРЭЛМАА/

УЛААНБААТАР ХОТ

2023 ОН

ГАРЧИГ

НЭГ. УУРХАЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА	3
ХОЁР. БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ-ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ	7
ГУРАВ. ТӨСЛИЙН ГОЛ БА БОЛЗОШГУЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ.	13
ДӨРӨВ. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГОЛ ЗОРИЛТ, ХАМРАХ ХҮРЭЭ	14
4.1. БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГОЛ ЗОРИЛТ	14
4.2. БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХАМРАХ ХҮРЭЭ	15
ТАВ. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ	16
ЗУРГАА. НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ	21
ДОЛОО. БИОЛОГИЙН ОЛОН ЯНЗ БАЙДЛЫГ ДҮЙЦҮҮЛЭН ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ	23
НАЙМ. НҮҮЛГЭН ШИЛЖҮҮЛЭХ, НӨХӨН ОЛГОВОР ОЛГОХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ	25
ЕС. ТҮҮХ, СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ	26
АРАВ. ОСОЛ, ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ	27
АРВАН НЭГ. ХОГ ХАЯГДАЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ	29
АРВАН ХОЁР. ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ТӨЛӨВӨР	30
АРВАН ГУРАВ. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЭРЭГЖҮҮЛЭХ УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ	31
АРВАН ДӨРӨВ. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙГ НӨЛӨӨЛЛИЙН БҮСИЙН ОРШИН СУУГЧДАД ТАЙЛАГНАХ ТӨЛӨВӨГӨӨ.	33
АРВАН ТАВ. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ 2023 ОНЫ НИЙТ ТӨСӨВ	35

ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт 1. MV-014228 тоот тусгай зөвшөөрлийн талбайн солбицлууд	3
Хүснэгт 2. Агаар орчинд нөлөөлөх байдал	7
Хүснэгт 3. Хөрсөн бүрхэвчинд нөлөөлөх байдал.....	8
Хүснэгт 4. Газрын доорх усанд нөлөөлөх байдал	9
Хүснэгт 5. Ургамлан нөмрөгт нөлөөлөх	10
Хүснэгт 6. Амьтны аймагт нөлөөлөх.....	11
Хүснэгт 7. Төслийн гол ба болзошгүй сөрөг нөлөөлөл	13
Хүснэгт 8. Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хүрээнд хийгдэх ажлууд	16
Хүснэгт 9. Нөхөн сэргээлтийн төлөвлөгөө	21
Хүснэгт 10. Биологийн олон янз байдлын дүйцүүлэн хамгаалах төлөвлөгөө.....	22
Хүснэгт 11. Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээний төлөвлөгөө.....	23
Хүснэгт 12. Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө	25
Хүснэгт 13. Осол, эрсдлийн менежментийн төлөвлөгөө.....	26
Хүснэгт 14. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө	28
Хүснэгт 15. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр	29
Хүснэгт 16. Удирдлага, зохион байгуулалтын төлөвлөгөө	31
Хүснэгт 17. БОМТ-ий хэрэгжилтийг тайлагнах хуваарь.....	33
Хүснэгт 18. Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний төсөв	35

ЗУРГИЙН ЖАГСААЛТ

Зураг 1. Эрээний нүүрсний уурхайн байршил.....	4
--	---

НЭГ. УУРХАЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

2.1. Төслийн ерөнхий мэдээлэл

“Илчит металл” ХХК нь 2005 оны 12-р сарын 08-нд байгуулагдсан ба Булган аймгийн Сайхан сумын нутаг, Эрээний ихэр уул нэртэй газарт орших 65,59 га талбайд MV-014228 тоот ашигт малтмал ашиглалтын тусгай зөвшөөрлийг 2008 оны 09-р сарын 30-ний өдөр 30 жилийн хугацаагаар авсан.

Эрээний нүүрсний орд газар нь засаг захиргааны хувьд Улаанбаатар хотоос баруун зүгт 400 км, Эрдэнэт хотоос баруун зүгт 168 км, Булган аймгаас баруун зүгт 100 км, Булган аймгийн Сайхан сумаас баруун хойд зүгт, ашиглаж дууссан Сайхан овоогийн нүүрсний уурхайгаас зүүн зүгт 11 км тус тус зайтайгаар оршино.

Ашиглалтын тусгай зөвшөөрлийн талбай нь Орхон Сэлэнгийн геологи-тектоникийн бүст орших ба Ордын районы гадаргуу нь дов толгодорхуу, хамгийн өндөр цэг нь Сайхан уул бөгөөд далайн түвшнээс дээш 1856 м өндөрт оршдог. Ордын талбай нь газарзүйн байрлалаар Төв монголын төвийн атираат мужийн хойд хэсэгт хамаарагдана. Манай орны Хангай-Хөвсгөлийн уулсын зүүн хэсэг Хангайн нурууны төдийлөн өндөр биш уулс нуруу бүхий, өмнөд хэсгийн үргэлжлэл бөгөөд ерөнхийдөө ойт хээрээс тал хээрт шилжсэн завсрын бүсэд багтдаг.




1:1000000-ны масштабтай планшетиин М-48-109 хавтгайд оршино.

“Илчит металл” ХХК-ийн эзэмшдэг MV-014228 тоот ашигт малтмал ашиглалтын тусгай зөвшөөрлийн талбайн булангийн цэгүүдийг дараах хүснэгтэд үзүүлэв.

Хүснэгт 1. MV-014228 тоот тусгай зөвшөөрлийн талбайн солбицлууд

Цэгийн дугаар	Уртраг			Өргөрөг		
	Градус	Минут	Секунд	Градус	Минут	Секунд
1	102	34	40,75	48	48	26,84
2	102	34	0,74	48	48	26,84
3	102	34	0,74	48	48	52,83
4	102	34	40,75	48	48	52,83

Булган аймгийн Сайхан сумын нутагт байрлах MV-014228 тоот ашигт малтмал ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй Эрээний нүүрсний уурхайн 2023 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөө



Зураг 1. Эрээний нүүрсний уурхайн байршил

“Илчит металл” ХХК нь “Эрээний нүүрсний” ордын нөөцийн тооцоонд хийсэн шинжээчдийн дүгнэлт, зөвлөлийн гишүүдийн саналыг үндэслэн УУХҮЯ, АМГТГ-ын Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн 2020 оны 07-р сарын 06-ний өдрийн хуралдаанаар ХХ-10-18 тоот дүгнэлтийг үндэслэн гаргасан, Нүүрсний ордын нөөцийг 2019 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн байдлаар нь бодитой (В) нөөцийг 342482,34 тн, боломжтой (С) нөөцийг 317019,56 тн, тн-оор, бодитой болон боломжтой (В+С) нөөцийг 659501,9 тн-оор тус тус ашигт малтмалын нөөцийн улсын бүртгэлд бүртгүүлсэн байна.

Төсөл үйлдвэрлэлийн нөөцийг тооцохдоо ашиглалтын үед бохирдол 6% /13,0 мян.тн/, хаягдал 3% /6.3 мян.тн/ байхаар тооцоолон үйлдвэрлэлийн нөөцөд шилжүүлэн ил уурхайгаас 21705 мян.тн нүүрс олборлохоор төлөвлөсөн байна.

“Илчит металл” ХХК нь Булган аймгийн Сайхан сумын нутаг, Эрээний ихэр уул нэртэй газарт орших 65,59 га талбайд MV-014228 тоот ашигт малтмал ашиглалтын тусгай зөвшөөрлийг 2008 оны 09-р сарын 30-ний өдөр 30 жилийн хугацаагаар авсан. Улмаар тус ордыг ил аргаар ашиглах ТЭЗҮ-ийг 2020 оны 07 сарын 06-ны өдөр УУХҮЯ-ы АМГТ-ын ЭБМЗ-ийн ХХ-10-18 дугаар дүгнэлтээр хэлэлцэж батласан.

2020 оны 08 сарын 14-ны өдөр УУХҮЯ-ы АМГТ-ын даргын Н/74 тоот тушаалаар ТЭЗҮ-ийг хүлээн авсан. Мөн ТЭЗҮ-ийг уул уурхайн зураг төслийн “Этолл майнинг” ХХК-иар боловсруулуулан 2021 оны 02 сарын 10-нд АМГТГ-ын ЭБМЗ-ийн Т/21-02-09 дугаар дүгнэлтээр ТЭЗҮ-ийг хэлэлцэж батласан. Эрээний нүүрсний ил уурхайн ТЭЗҮ-ээр жилд дунджаар 45 мян.тн нүүрс олборлон ордын нөөцийг 5 жилийн хугацаанд ашиглахаар тооцсон байна.

“Илчит металл” ХХК нь 2021 онд байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний тайланг “Хос Нахиа” ХХК-иар боловсруулуулан БОАЖЯ-аар батлуулсан.

Эрээний нүүрсний уурхай нь 2023 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөг байгаль орчны нарийвчилсан үнэлгээний тайлан болон Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2019 оны 10 дугаар сарын 29-ний өдрийн А/618 тоот тушаал “Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах журам”-ын дагуу боловсруулав.

2.2. Төслийн хүчин чадал, ажиллах горим

Тус ордын геологийн тогтоц, гидрогеологи, уул-геологи, уул-техникийн нөхцлөөс хамааруулан уурхайн хөрс хуулалт, нүүрс олборлолтын ажлыг эксковатор-автосамосвалын хослол бүхий тээвэртэй ашиглалтын системээр ил аргаар ашиглалт явуулдаг.

“Эрээний нүүрсний ордыг ашиглах техник, эдийн засгийн үндэслэл”-ийг 2021 онд боловсруулж батлагдсан ТЭЗҮ-ийн дагуу уулын ажлыг явуулж байна. Тус ордын нүүрс бодитой /В/ зэргээр 324.5 мянган тн, нүүрс боломжтой /С/ зэргээр 317.0 мянган тн, 659.5 мянган тн батлагдсан нөөцтэй.

Эрээний нүүрсний уурхай нь жилд 50.0 мян.тн нүүрс олборлох хүчин чадлаар 10 жил ашиглана.

Уурхайн ажиллах горим: “Илчит металл” ХХК-ийн Эрээний нүүрсний уурхай нь ажиллах хүчний хувьд мэргэшсэн, тогтворжсон 36 ажилчидтай. 1 ээлжийн ажлын горимоор ээлжийн үргэлжлэх хугацаа 12 цагаар долоо хоногт 5 өдөр ажилладаг.

Ил уурхай нь дулааны улиралд хөрс хуулалт, нүүрс олборлолтыг зэрэг явуулж, хүйтний улиралд зөвхөн нүүрс олборлолтын ажил хийнэ. Амралт, баяр ёслол, цаг агаарын саатал ба бусад нөлөөллийн өдрүүдийг тооцоод жилд 305 хоног ажиллана.

д/д	Үзүүлэлт	Хэмжих нэгж	Тоо хэмжээ
1	Хөрс хуулалт хийх хоног	Хоног	175
2	Нүүрс олборлолт хийх хоног	Хоног	305
3	Жилд ажиллах нийт хоног	Хоног	325
4	Ажиллах сар	Сар	8-10
5	Хоногт ажиллах ээлжийн тоо	Тоо	2
6	Ээлжийн үргэлжилэх хугацаа	цаг	12
7	Хоногт ажиллах цэвэр ажлын цаг	цаг	20
8	Саатлын хоногууд	хоног	20
9	Цэвэр ажиллах хоног	хоног	305

ХОЁР. БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ-ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ БАЙДАЛ

2.1. Төсөл хэрэгжиж буй нутгийн байгаль орчны төлөв байдал

Агаар орчин: Агаарын бохирдолт гэдэг нь үйлдвэрлэлийн үйл ажиллагааны явцад үүссэн хорт хий, тоос болон бусад бодисын нөлөөгөөр агаарын чанарын хүлцэх хэмжээнд гарсан өөрчлөлт юм.

Эрээний нүүрсний уурхай ашиглах төслийн зүгээс агаарын чанарт үзүүлэх сөрөг нөлөөлөл нь хөрс хуулах, овоолго үүсгэх, машин механизмын хөдөлгөөнөөс тоос босох, хөдөлгүүрээс тоос босох зэрэг болно. Тухайлбал:

- Хөрс хуулах, овоолго үүсгэх үед тоос шороо ихээр дэгдэх,
- Уурхайн малталтууд болон овоолгын дээд талбайгаас сул хөрс салхинд хийсч, тоос шороо босох,
- Уурхайд ажиллах машин механизмын хөдөлгүүрийн шаталтаас утаа, хөө тортог, хорт хийнүүд агаарт хаягдах,
- Ашиглалтын хугацаанд нүүрс олборлолттой холбоотой бүхий л үйл ажиллагаа тасралтгүй явагдах тул дуу чимээ, утаа тортог, тоос шороо дэгдэх зэргээр агаар орчныг бохирдуулж, хүний эрүүл мэнд, хүрээлэн буй орчинд сөргөөр нөлөөлж болзошгүй.

Хүснэгт 2. Агаар орчинд нөлөөлөх байдал

№	Үйл ажиллагаа	Агаарын чанар			
		Болзошгүй нөлөөлөл	Нөлөөллийн үр дагавар	Нөлөөллийн магадлал	Нөлөөллийн үнэлгээ
1	Хөрс хуулалт	Шимт хөрс хуулах, хоосон чулуулгийн ухалт хийгдэх үед их хэмжээний тоос агаарт дэгдэх	Дунд	Болзошгүй	Дунд
2	Олборлолт	Олборлолтын явцад ухах, ачих, тээвэрлэх, овоолгод байршуулах зэрэг үйл ажиллагаанаас тоосжилт үүсэх	Дунд	Их	Их
3	Овоолго үүсгэх	Шимт хөрс, хаягдал чулуулгийн овоолго үүсгэх явцад тоосжилт үүсэх	Дунд	Болзошгүй	Их
4	Гадаад тээвэрлэлт	Хүнд даацын машин механизмын хөдөлгөөнөөр хөрсөн бүрхэвч элэгдэн, сул шороо үүссэнээр тоосжилт ихсэх	Дунд	Болзошгүй	Дунд
5	Засвар үйлчилгээ	Шатах тослох материал болон нефтийн бүтээгдэхүүний асгаралтаас ууршимтгай органик нэгдлүүд агаарт дэгдэх	Дунд	Болзошгүй	Дунд
6		Машин техник, тоног төхөөрөмжийн хөдөлгүүрийн яндангаас гарах утаа тортог зэрэг нь агаарын чанарт нөлөөлөх	Дунд	Болзошгүй	Дунд
7	Шатахуун хадгалах, түгээх	Шатахуун түгээх үед ууршиж агаарт дэгдэх, хадгалалтын горим алдагдсанаас хөрсөнд нэвчих	Дунд	Болзошгүй	Дунд

Хөрсөн бүрхэвч: Төслийн үйл ажиллагааны явцад шимт хөрс хуулах, ил уурхай, овоолго үүсгэх зэрэг уулын бүхий л үйл ажиллагаагаар тодорхой талбайн хөрс хуулагдаж, үржил шимт хөрс

болон ургамлан нөмрөг зайлуулагдана. Мөн олборлолтын машин механизм, тоног төхөөрөмж, тэдгээрт ашиглагдах шатах тослох материалын асгаралт зэргээс хөрсөн бүрхэвч бохирдох эрсдэлтэй.

Хүснэгт 3. Хөрсөн бүрхэвчинд нөлөөлөх байдал

№	Үйл ажиллагаа	Хөрсөн бүрхэвч			
		Болзошгүй нөлөөлөл	Нөлөөллийн үр дагавар	Нөлөөллийн магадлал	Нөлөөллийн үнэлгээ
1	Барилга байгууламж барих	Уурхайд шинээр барилга байгууламж барих үед тухайн орчны өнгөн хөрс элэгдэх, үржил шимт чанар алдагдах	Дунд	Дунд	Дунд
2	Хөрс хуулалт	Нүүрс олборлолтын хэмжээ нэмэгдсэн үед хөрс хуулалт хийгдэх ба тухайн талбайн хөрсөн бүрхэвч гадаргаас зайлуулагдах	Дунд	Дунд	Их
3	Хөрсний гадаад овоолго үүсгэх	Хөрсний гадаад овоолго үүсгэх талбайн хөрс уурхайн ашиглалтын хугацаанд овоолгын дор дарагдах, хөрсний унаган хэв шинж өөрчлөгдөх	Их	Их	Их
4	Хүнд даацын машин механизмын хөдөлгөөн	Машин техникээс тос тосолгооны материал асгарч хөрс бохирдуулах	Их	Болзошгүй	Дунд
5		Ил уурхайгаас хуулах хөрсийг автосамосвалаар тээвэрлэх ба түүний нөлөөгөөр хөрсөн бүрхэвч элэгдэж, эвдрэлд орох, сул шороо ихээр үүсэх	Дунд	Их	Их
6	Засвар үйлчилгээ	Шатах тослох материал болон нефтийн бүтээгдэхүүний асгаралтаас хөрс бохирдох	Дунд	Болзошгүй	Дунд
7	Уурхайн гал тогоо, бусад үйлчилгээ	Уурхайн гал тогоо, угаалгаас гарах шингэн хаягдал, мөн хоолны үлдэгдэл, хог хаягдал зэргийн нөлөөгөөр хөрс бохирдох	Дунд	Их	Их

Усан орчин: Төсөл хэрэгжих талбайн ойр орчимд гадаргын уст цэг байхгүй тул гадаргын усанд сөрөг нөлөөлөл үзүүлэхгүй.

Төслийн үйл ажиллагааны үед ахуйн бохир ус, хатуу хог хаягдал, нефтийн бүтээгдэхүүн, шатах тослох материал ил задгай хаяж алдагдсанаас хур борооны усаар угаагдан гүний усны чанарт шууд сөргөөр нөлөөлж болзошгүй.

Хүснэгт 4. Газрын доорх усанд нөлөөлөх байдал

№	Үйл ажиллагаа	Усан орчин			
		Болзошгүй нөлөөлөл	Нөлөөллийн үр дагавар	Нөлөөллийн магадлал	Нөлөөллийн үнэлгээ
1	Тоосжилт бууруулах үйл ажиллагаа	Орчны тоос бууруулахад ус ашигласны улмаас усны нөөц хомсдох	Хөнгөн	Бага	Бага
2	Ил уурхайд орж ирэх усыг шүүрүүлэх	Уурхайн гүн доошлохын хэрээр усны шүүрэлт ихэсч, уурхайгаас зайлуулах усны хэмжээ нэмэгдэж газрын гүний ус хомсдох	Дунд	Болзошгүй	Дунд
3	Шатахуун хадгалах, түгээх	Шатах тослох материал хадгалах, түлш, шатахууныг түгээх, хэрэглэх явцад хөрс, агаар, гадаргын болон гүний ус бохирдох	Дунд	Бага	Дунд
4	Засвар үйлчилгээ	Шатах тослох материал болон нефтийн бүтээгдэхүүн зэрэг бодис алдагдах, хур тунадас болон үерийн усаар угаагдан усан орчинг бохирдуулах	Дунд	Бага	Дунд
5	Уурхайн ухаш үүсэх, далан байгуулах	Уурхайн ухаш үүсэх, далан байгуулах, суваг шуудуу татах, хөрс эвдрэлд оруулах зэргээр газрын гадаргын хэлбэр дүрсийг өөрчилснөөр гадаргын урсацын байгалийн унаган тогтоц өөрчлөгдөх	Дунд	Бага	Дунд

Ургамлан нөмрөг: Төслийн үйл ажиллагааны явцад дараах эх үүсвэрүүдээс ургамлан нөмрөгт сөрөг нөлөөлөл үзүүлж болзошгүй. Үүнд:

- Талбайн үржил шимт хөрс хуулснаар тус талбайн ургамлан нөмрөг усах,
- Машин механизмын хөдөлгөөнөөр олон салаа зам гаргаснаар ургамал талхлагдаж доройтон цаашлаад устаж болзошгүй.
- Тоосжилтын улмаас ургамлан нөмрөг доройтох.

Хүснэгт 5. Ургамлан нөмрөгт нөлөөлөх

№	Үйл ажиллагаа	Ургамлан нөмрөг			
		Болзошгүй нөлөөлөл	Нөлөөллийн үр дагавар	Нөлөөллийн магадлал	Нөлөөллийн үнэлгээ
1	Барилга байгууламж барих	Барилга байгууламж барих үйл ажиллагааны үед тухайн талбайн ургамлан нөмрөг талхлагдах, ургах чадвараа алдах, устах	Дунд зэрэг	Бага	Дунд
2	Хөрс хуулалт	Нүүрс олборлолтын үед хөрс хуулалт хийгдэх ба тухайн талбайн ургамлан нөмрөг хөрстэй хамт устах	Дунд зэрэг	Их	Их
3	Хөрсний гадаад овоолго үүсгэх	Хөрсний гадаад овоолго үүсгэх талбайн ургамлан нөмрөг уурхайн ашиглалтын хугацаанд овоолгын дор дарагдах	Дунд зэрэг	Болзошгүй	Их
4	Хүнд даацын машин	Машин техникээс тос тосолгооны материал асгарч ургамлан нөмрөг, хөрс, гүний усыг бохирдуулах	Дунд зэрэг	Бага	Дунд
5	механизмын хөдөлгөөн	Ил уурхайгаас хуулах хөрсийг тээвэрлэх ба түүний нөлөөгөөр ургамлан нөмрөг талхлагдах, ургах чадвараа алдах	Дунд зэрэг	Бага	Дунд
6	Засвар үйлчилгээ	Шатах тослох материал болон нефтийн бүтээгдэхүүний асгаралтаас ургамлан нөмрөг, хөрс, гүний ус бохирдох	Дунд зэрэг	Болзошгүй	Бага
7	Уурхайн гал тогоо, бусад үйлчилгээ	Уурхайн гал тогоо, угаалгаас гарах шингэн хаягдал, мөн хоолны үлдэгдэл, хатуу хог хаягдал зэргийн нөлөөгөөр хөрс, ургамлан нөмрөг бохирдох	Дунд зэрэг	Бага	Дунд

Амьтны аймаг: Төслийн үйл ажиллагааны явцад дараах эх үүсвэрүүдээс амьтны аймагт нөлөөлөл үзүүлж болзошгүй. Үүнд:

- Барилга байгууламжийн ажлын үед ажиллах хүнд даацын автомашин, техник хэрэгслүүдийн дуу чимээнээс зэрлэг амьтан үргэн дайжих,
- Төслийн үйл ажиллагааны явцад ялгарсан, асгарсан бохирдуулагч материалууд ургамлан нөмрөгт хуримтлагдсанаар өвсөн тэжээлт зэрлэг амьтад хордох,
- Тоосжилтын улмаас ургамал ургах чадвараа алдан ургамлын арви багассанаар өвсөн тэжээлт зэрлэг амьтдын бэлчээр, тархац нутаг хумигдах,
- Уурхайн ухашт зэрлэг амьтад, мал унаж бэртэх,
- Зэрлэг амьтдын тархац нутаг хумигдах, амьдрах орчны хуваагдал үүсэх зэргээр сөрөг нөлөөлөл үзүүлж болзошгүй.

Хүснэгт 6. Амьтны аймагт нөлөөлөл

№	Үйл ажиллагаа	Амьтны аймаг			
		Болзошгүй нөлөөлөл	Нөлөөллийн үр дагавар	Нөлөөллийн магадлал	Нөлөөллийн үнэлгээ
1	Барилга байгууламж барих	Ил уурхай үүсч уурхайн барилга байгууламж баригдсанаар амьтдын амьдрах орчин алдагдах, тархац нутаг хумигдах	Дунд зэрэг	Бага	Бага
2	Хөрс хуулалт	Хөрсөнд үүрлэдэг жижиг хөхтөн амьтад, бусад шавж зэрэг амьд биетүүдийн амьдрах орчин алдагдах, сүйтгэгдэх	Дунд зэрэг	Болзошгүй	Дунд
3		Тоосжилтын улмаас уурхайн ойр орчмын амьтдын амьдрах орчин доройтох	Бага	Болзошгүй	Дунд
4	Хөрсний гадаад овоолго үүсгэх	Амьтдын амьдрах орчны унаган төрх, хэв шинж алдагдах	Бага	Бага	Дунд
5	Хүнд даацын машин	Уурхай орчмын жижиг амьтад машин механизмд дайрагдах	Бага	Бага	Бага
6	механизмын хөдөлгөөн	Машин механизмын хөдөлгөөн дуу чимээнээс амьтад дайжих	Дунд зэрэг	Бага	Дунд
7	Шатахуун хадгалах, түгээх	Шатахуун, шатах тослох материал болон нефтийн бүтээгдэхүүний асгаралтаас амьтдын амьдрах орчин бохирдох, доройтох	Бага	Болзошгүй	Бага

Түүх, соёлын дурсгалт зүйлс: Төсөл хэрэгжүүлэгч “Илчит металл” ХХК нь тус ордын хайгуулын шатны ажлын үед палеонтологийн судалгааг 2020 онд Стратиграфи-Палеонтологийн судалгааны төвөөр хийлгэсэн бөгөөд тусгай зөвшөөрлийн талбайгаас эртний амьтан ургамлын чулуужсан үлдэгдэл илрээгүй. Мөн уурхайн ашиглалтын талбайд нүдэнд ил харагдах түүх соёлын дурсгал илрээгүй.

2.2. Нийгэм-эдийн засаг

MV-014228 тоот ашигт малтмал ашиглалтын тусгай зөвшөөрлийн талбай байрлах Булган аймгийн Сайхан сум нь 1930 онд Богд хан уул аймгийн Булган хан уулын хошууны харъяанд байгуулагджээ. Мануулт, Угалз, Хульж, Ундрах, Их хүрэмт, Сайхан-Овоо гэсэн 6 багт хуваагддаг. Хүн амын тоогоор Булган аймгийн 16 сумаас эхнээсээ 3-т, газар нутгийн хэмжээгээрээ 7-д ордог.

Сайхан сум нь өмнө талаараа Могод, баруун өмнө, баруун талаараа Архангай аймгийн Өлзийт, Хайрхан сум, хойд талаараа Баян-Агт, зүүн хойд талаараа Хутаг-Өндөр сум, зүүн талаараа Бугат, Орхон сумтай хиллэдэг.

Далайн түвшнээс дээш 1500-2080 м өндөрт өргөгдсөн. Газар хөдлөлийн эрчим 9-10 балл. Сумын нутаг дэвсгэр нь уул, гүвээ толгод бүхий тал хээр буюу мал аж ахуй болон газар тариалан эрхлэхэд тохиромжтой.

Ордын районы гадаргуу нь дов толгодорхуу, хамгийн өндөр цэг нь Сайхан уул бөгөөд далайн түвшнээс дээш 1856 м өндөрт оршдог. Ордын талбай нь газарзүйн байрлалаар Төв монголын төвийн атираат мужийн хойд хэсэгт хамаарагдана. Манай орны Хангай-Хөвсгөлийн уулсын зүүн хэсэг Хангайн нурууны төдийлөн өндөр биш уулс нуруу бүхий, өмнөд хэсгийн үргэлжлэл бөгөөд ерөнхийдөө ойт хээрээс тал хээрт шилжсэн завсрын бүсэд багтдаг.

Эрээний нүүрсний уурхай нь Сайхан уулаас зүүн тийш 10 гаруй км-т Эрээний ихэр уул(далайн түвшнээс дээш 1883.4 м өндөрт өргөгдсөн)-ын өмнөд зах сэжүүр хэсэг, сумын төвийн хойт хэсгээр үргэлжлэх Бөөрийн хөндий(д.т.д 1500-1600 метрийн өндөр)-н хойт зах хэсгийн нутгийг хамран байрлана.

ГУРАВ. ТӨСЛИЙН ГОЛ БА БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ

Газрын хэвлийгээс ашигт малтмалыг олборлох бүх арга технологиуд газар ба түүний хэвлийг хөндөж, экологийн тэнцвэртэй байдалд шууд ба дам байдлаар төсөл хэрэгжиж дуусах хүртэлх хугацаанд их эрчимтэйгээр нөлөөлдөг онцлогтой. Голлох сөрөг нөлөөллийг дараах байдлаар тодорхойлон үзүүлэв.

Хүснэгт 7. Төслийн гол ба болзошгүй сөрөг нөлөөлөл

№	Төслийн гол нөлөөлөл	Нөлөөлөлд өртөгч	Хамрах хүрээ	Нөлөөллийн эрчим	Үргэлжлэх хугацаа
1	Олборлолт	Геологийн тогтоц	Жилд дунджаар 45 мян.тн нүүрс олборлоно.	Дунд зэрэг	Төсөл хэрэгжих хугацаанд
2	Тээвэр	Хөрс, агаар	Авто замаас босох тоос шороо болон дотоод шаталтад хөдөлгүүртэй тээврийн хэрэгслийн яндангаас гарах бохирдуулагч хий зэрэг ялгарч агаар орчныг бохирдуулна.	Дунд зэрэг	Төсөл хэрэгжих хугацаанд
3	Овоолго	Хөрс, агаар, ургамал	Овоолгын байршил болон багтаамж зэргийг уурхайн уул техникийн нөхцөлтэй уялдуулж тодорхойлно. Ил уурхайн үндсэн малталтаас гарах уулын цулыг хөрс болон хоосон чулуулгийн овоолгод байрлуулна.	Их	Төсөл хэрэгжих хугацаанд

Байгаль орчны менежментийн тухайн жилийн төлөвлөгөөний гол зорилт нь энэхүү төслийг хэрэгжүүлэх үед технологийн онцлогоос хамааран газрын хөрс, түүний дээрх ургамал, газрын хурдас болон агаар мандалд тоос босох зэрэг сөргөөр нөлөөлөх тул байгаль орчны мониторингийг тогтмол хийх, түүнийг нөхөн сэргээх ажлыг байгаль хамгаалах төлөвлөгөө, санхүүжилтэндээ тусган гүйцэтгэж ажиллахад оршино.

ДӨРӨВ. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГОЛ ЗОРИЛТ, ХАМРАХ ХҮРЭЭ

4.1. Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөний гол зорилт

MV-014228 тоот ашигт малтмал ашиглалтын тусгай зөвшөөрөл бүхий нүүрсний уурхайн төслийн байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний тайланг “Хос Нахиа” ХХК-иар 2021 онд хийлгэсэн.

Тус үнэлгээний үр дүнг тоймлон авч үзэхэд Эрээний нүүрсний уурхайн ордыг ил аргаар ашиглах төслийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд анхаарах шаардлагатай асуудлууд болон гол чухал зорилтууд нь дараах байдлаар тодорхойлогдоно. Үүнд:

- Уурхайн үйл ажиллагааны улмаас өртөгдөх нүүрсний овоолгуудад жил бүрийн уулын ажлын төлөвлөлт болон тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хүрээнд холбогдох аргачлал, стандартын дагуу техникийн ба биологийн нөхөн сэргээлтийг явуулж орон нутагт хүлээлгэн өгөх,
- Уурхайн хаалт-нөхөн сэргээлтийн төлөвлөгөөг мэргэжлийн байгууллагатай хамтран боловсруулах, орон нутгийн иргэдээр хэлэлцүүлж, төрийн захиргааны төв байгууллагаар батлуулах,
- Уурхайн талбайд байгаль орчны үйл ажиллагааг хариуцан зохион байгуулах албан тушаалтныг томилж, байгаль орчны чиглэлээр дотоодын хяналт ба ажилчдад зориулсан сургалт сурталчилгааг тогтмол явуулж хэвших,
- Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн дагуу жил бүрийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг боловсруулж, гүйцэтгэлийг өндөр түвшинд байлгах, байгаль орчны аудитыг хийлгэх,
- Уурхайн үйл ажиллагаа ба барилга байгууламж, ажилчдын байрнаас үүсэх хог хаягдалтай холбоотойгоор хог хаягдлын менежментийн 3R зарчмыг хэрэгжүүлж, үүсэх хог хаягдлыг багасгах, түүнийг дахин ашиглах, дахин боловсруулах ажил зохион байгуулах,
- Орчны хяналт шинжилгээг хуваарийн дагуу явуулж уурхайн үйл ажиллагаанаас үзүүлэх гол ба болзошгүй сөрөг нөлөөлөлд хяналт тавих,
- Үйл ажиллагааны явцад үүсэх орчны тоосжилтыг хамгийн бага байлгахад анхаарч ажиллах, БОННУ-ий тайлангийн холбогдох зөвлөмжийг хэрэгжүүлэх зэрэг болно.

4.2. Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөний хамрах хүрээ

Агаар: “Илчит металл” ХХК нь уурхайн цэгэн эх үүсвэрүүдээс үүсэх сөрөг нөлөөллийн цар хүрээ, хамрах эрчим, хэмжээг бууруулах, арилгах, урьдчилан сэргийлэх арга хэмжээнүүдийг 2023 онд авч хэрэгжүүлж ажиллана.

Хөрс, газрын гадарга: Уурхайн олборлолтын явцад ашиглалтын үйл ажиллагааны төлөвлөгөөний дагуу хийж гүйцэтгэнэ.

Уурхайд олон салаа зам гаргахгүйн тулд дотоод замыг стандартын дагуу байгуулж олборлолтоос гарсан материалаар хучиж тоосжилтыг бууруулах ажлыг үргэлжлүүлэн хийнэ.

2023 онд орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн дагуу хөрсний чанарын шинжилгээнүүдийг мэргэжлийн байгууллагаар хийлгэж сөрөг нөлөөлөл илэрвэл хариу арга хэмжээ авч ажиллана.

Усан орчин: 2023 онд уурхайн өрөмдлөг-тэсэлгээ, нөхөн сэргээлт, зам талбайн тоос дарахад ашиглах усыг уурхайн шүүрлийн усаар хангахаар тооцсон. Харин унд ахуйн хэрэглээний усыг төслийн талбайд гаргасан гүний худгаас хангана. Тус гүний худгийн уснаас дээж авч шинжлүүлэх ажлыг байгаль орчны нарийвчилсан үнэлгээний дагуу орчны хяналт шинжилгээний хөтөлбөрт тусган хэрэгжүүлнэ.

Ургамлан нөмрөг: Уурхайн ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй талбай дахь ургамлан нөмрөгийг аль болох хөндөхгүй байх талаар анхаарч ажиллана. Мөн хөрс хуулалтанд өртөж байгаа газрын шимт хөрсийг тусад нь хадгалж биологийн нөхөн сэргээлтэнд ашиглана.

Биологийн нөхөн сэргээлтийг уурхайн ашиглалтанд өртөхөөс өмнөх жилүүдэд хийсэн ургамалжилтын судалгаатай харьцуулан ойролцоо түвшинд байхаар хийнэ.

Амьтан: Төслийн үйл ажиллагааны улмаас амьтны аймагт үзүүлэх нөлөөллийг бууруулах, тухайн сонгон авсан талбайд амьтдын амьдрах орчинг сайжруулах зорилгоор дүйцүүлэн хамгаалах ажлуудыг хийхээр БОННУ-ий тайланд тусгана.

“Тэрбум мод” үндэсний хөдөлгөөнд доорхи байдлаар оролцож хэрэгжүүлэхээр 2023 оны уулын ажлын батлагдсан төлөвлөгөөнд тусгасан.

АМГТГазрын нүүрс судалгааны хэлтэсийн даргын 2022 оны 7/579 тоот албан бичигт заасан “тухайн онд эвдрэлд орсон талбайн 1га тутамд 1000 мод” гэсэн хувилбараар тооцон дараах арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.

2023 онд уулын ажилд өртөгдөх нийт талбайн 68 хувь нь буюу 1.06 га газар шинээр өртөгдөх тул 1000 ширхэг мод тарихаар төлөвлөгөөнд тусгаж зардалыг 2023 оны хөрөнгө оруулалтын зардалд тусгасан.

Уулын ажлын төлөвлөгөөний 10-р маягт “Байгаль орчны нөхөн сэргээлт” мөн зардалыг 17-р маягт “Хөрөнгө оруулалтын бүтэц” зэрэг нэгдсэн хүснэгтүүдэд тооцон оруулаж уурхайчидын сууринд тариж ургуулсан ойн зурвасд шинээр 1 зурвас / 260ш мод / Сайхан сумын уурхай байрладаг 6-р багын нутаг болох “Ороохын даваа”-ны ойн өмнөх жилүүдэд нөхөн сэргээлтээр тарьсан талбайд үргэлжилүүлэн 740 ш шилмүүст суулгац суулгахаар тус тус төлөвлөн хэрэгжүүлнэ.

ТАВ. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

Хүснэгт 8. Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хүрээнд хийгдэх ажлууд

№	Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	Урьдчилан сэргийлэх, бууруулах, арилгах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэм жих нэгж	Нэгжийн зардал, мян.төг	Тоо хэмжээ	Нийт зардал, мян.төг	Хэргжүүлэх хугацаа, давтамж	Баримтлах эрхзүйн баримт бичиг
1	2	3	4	5	6	7	8	9	
Агаарын чанар									
1.		18 м/с-ээс дээш хүчтэй салхитай үед үйл ажиллагааг түр зогсоох	Уурхайн овоолгууд, газрын гадарга дээр явагдах технологийн бусад ажлууд	-	-	-	-	Салхины хүч ихээр нэмэгдэх үед	MNS 3113:1981 “Агаар мандлын бохирдлыг хэмжих аргачлалын ерөнхий шаардлага”
2.	Олборлолтын явцад ухах, ачих тэвэрлэх, овоолгод байршуулах зэрэг үйл ажиллагаанаас тоосжилт үүсч агаарын чанарт нөлөөлөх	Уурхайн гадаад дотоод замыг чийгшүүлж усалгаа хийх	Уурхайн хүрээнд	-	-	-	-	Хуурайшилттай үед 7 хоногт 1-2 удаа	MNS 3384:1982 “Агаар мандал-Агаарын дээжлэлт шинжилгээ”
3.		Үйл ажиллагаанаас үүсэх тоосжилт бууруулах зорилгоор тоос дарагч ашиглах	Уурхайн талбайн дотоод болон гадаад замууд	-	-	-	800.0		Агаарын чанар. Техникийн ерөнхий шаардлага. MNS4585:2007 Агаарт байх бохирдуулах бодисын хүлцэх хэм хэмжээ. Техникийн ерөнхий шаардлага. MNS 5885:2008 Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуй. Ажлын байрны агаар дахь тоосны агуулгыг хэмжихэд тавигдах ерөнхий шаардлага. MNS 5010:2001 “Усны нөөц ашигласны төлбөрийн хувь хэмжээг тогтоох, хөнгөлөх” тухай Засгийн газрын 2013 оны 326-р тогтоол
4.		Уур нөлөөлөх амьсгалд нөлөөллийг бууруулах, сөрөг эрчим	Уурхайн талбайн болон тосгоны улайсах гэрлүүд				50.0		

		хүчийг хэмнэж үр ашигтай зарцуулах /Лед болон нарны зайгаар ажилладаг гэрлээр солих/							
5.	Машин техник, тоног төхөөрөмжүүдийн яндангаас гарах утаа тортог, бусад элемент зэрэг нь агаарын чанарт нөлөөлөх	Тээврийн хэрэгслүүдэд Монгол улсад мөрдөгдөж буй утааны ба бохирдлын стандартууд, олон улсын холбогдох стандарт шаардлагын дагуу хяналт хийж, түүнд нийцүүлэх	Уурхайд ажиллаж байгаа бүх машин механизм	-	-	-	Үйл ажиллагааны зардалд тусгасан	Үйл ажиллагааны туршид	MNS 5885:2008 “Агаарт байх бохирдуулах бодисын хүлцэх хэм хэмжээ, техникийн ерөнхий шаардлага” MNS 6063:2010 “Агаарын чанар, хот суурин газрын гадаад орчны агаарт байх бохирдуулах бодисын хүлцэх хэм хэмжээ”
6.	Ашиглагдаж буй машин техникүүдээс ялгарах хорт утааг стандартын түвшинд байлгах, агаар бохирдуулсны төлбөрийг төлөх, техникийн үзлэг, засвар үйлчилгээг тогтмол хийж байх	Ашиглагдаж буй машин техникүүдээс ялгарах хорт утааг стандартын түвшинд байлгах, агаар бохирдуулсны төлбөрийг төлөх, техникийн үзлэг, засвар үйлчилгээг тогтмол хийж байх		-	-	-	Үйл ажиллагааны зардалд тусгасан	Үйл ажиллагааны туршид	MNS 4990:2000 “ХААЭА, Ажлын байрны орчин, эрүүл ахуйн шаардлага”
Хөрсөн бүрхэвч									
7.	Шимт хөрсийг хуучин овоолгонд нэмж хадгалан нөхөн сэргээлт, ногоон байгууламжид эрүүлэх ашиглах, бүртгэл хөтлөх, тооцоог хянах	Шимт хөрсний овоолго хийх талбай, төслийн талбай	Шимт хөрс хуулах, овоолго хийх, дахин ашиглах үед	Уулын үйлдвэрлэлийн зардалд орсон					Газар шорооны ажлын үед шимт хөрс хуулалт, хадгалалт MNS 5916:2008 MNS 3297:1991 “Байгаль хамгаалал, Хөрс, Хот суурин газрын хөрсний ариун цэврийн үнэлгээний норм”, MNS 4919:2000 “Эвдэрсэн газарт хучилт хийх хөрс, техникийн шаардлага”, MNS 5850:2008 “Хөрсний чанар, хөрс бохирдуулагч бодис, элементүүдийн зөвшөөрөгдөх дээд хэмжээ”

									Уурхайн байгуулалт	хөдөлмөр	зохион
8.		Авто замын дагуух анхааруулах самбар, таних тэмдгийг шинэчлэх	Уурхайн үндсэн ам болон технологийн замууд	-	-	-	-	Ашиглалтын нийт хугацаанд			
9.	Машин техникээс тос тосолгооны материал асгарч хөрс бохирдуулах	Техникийн засвар үйлчилгээний төвийн тээврийн хэрэгсэл засах талбайн хатуу хучилттай хэсэгт үргэлжлүүлэн хийсэн хайрган хучилтанд нэмэлт хийх	Уурхайн техникийн засвар үйлчилгээний төв				100.0				
10.	Шатах тослох материалын болон нефтийн бүтээгдэхүүний асгаралтаас хөрс бохирдох	Ашигласан тос, маслыг ил задгай асгахгүй зориулалтын тусгай саванд хадгалах	Уурхайн хэмжээнд	-	-	-	-	Жил бүр			
11.	Ил уурхайгаас хөрс хуулах, тээвэрлэх явцад хүнд даацын машин механизмын нөлөөгөөр хөрсөн бүрхэвч элэгдэж, эвдрэлд орох, сул шороо ихээр үүсэх	Уурхайн гадаад дотоод замын сүлжээг тодорхой болгох, маршрутыг тогтоох	Төсөл хэрэгжих цар хүрээгээр	-	Агаарын чанарын хэсэгт тусгагдсан	-	-	Үйл ажиллагааны туршид			
12.		Замын усалгааг тоосжилт ихтэй үед хийж байх		-		-	-				
13.	Уурхайн гал тогоо, угаалгаас гарах шингэн хаягдал, мөн хоолны үлдэгдэл, хатуу хог хаягдал зэргийн нөлөөгөөр хөрс бохирдох	Хог хаягдлыг зориулалтын ангилан ялгадаг саванд хадгалах	Уурхай болон уурхайн тосгонд	-	-	-	-	Үйл ажиллагааны туршид			
14.		Ахуйн гаралтай шингэн хаягдлыг зориулалтын био бэлдмэлээр тогтмол ариутгах	Төслийн талбай орчимд	-	Хог хаягдлын МТ-нд тусгагдсан	-	-	Үйл ажиллагааны туршид			
Усан орчин											

15.		Ус ашиглах гэрээг холбогдох байгууллагуудтай байгуулах	Ундны усны эх үүсвэр болон шүүрлийн ус	-	Үйл ажиллагааны зардалд тусгасан	-	-	Үйл ажиллагааны туршид	MNS 0900:2018 “Ундны ус, ундны усны хяналт шинжилгээ”,
16.	Ил уурхайн гүн нэмэгдсэнээр шүүрлийн ус ихэсч, уурхайгаас зайлуулснаар газрын гүний ус хомсдох	Усны бүх эх үүсвэрийг тоолууржуулах/ус шавхах насос, гүний худаг г.м/	Ундны усны эх үүсвэр болон шүүрлийн ус	-	Үйл ажиллагааны зардалд тусгасан	-	-	Үйл ажиллагааны туршид	MNS 3935:1986 “Ундны ус, ундны усны хяналт шинжилгээнд тавигдах шаардлага”,
17.		Гүний худгийн усны чанарыг жил бүр шинжлүүлэх	Гүний худаг				50.0		Байгаль орчин, ногоон хөгжлийн сайдын 2013 оны 05 дугаар сарын 16-ны өдрийн А-156 тоот тушаалын хавсралт
18.		Уурхайн шүүрч буй усыг зумпэд хадгалах ба цэвэрлэгдсэн усыг замын тоосжилт дарахад хэрэглэх	Уурхайн шүүрлийн ус хадгалах зумп, уурхайн технологийн талбай	Агаарын чанарын зардалд орсон				2023 оноос	“Усны нөөц ашигласны төлбөрийн хувь хэмжээг тогтоох, хөнгөлөх” тухай Засгийн газрын 2013 оны 326-р тогтоол
Ургамлан нөмрөг									
19.	Хөрс хуулалт хийгдэх үед тухайн талбайн ургамлан нөмрөг хөрстэй хамт гадаргаас зайлуулагдах	Эвдэрсэн газарт биологийн нөхөн сэргээлт хийж ургамалжуулах	ТНС хийсэн талбай					Уурхайн ашиглалтын дараа	Батлагдсан арга зүйн дагуу
20.	Хөрсний гадаад овоолго үүсгэх талбайн ургамлан нөмрөг уурхайн ашиглалтын хугацаанд овоолгын дор дарагдах		Уурхайн талбай орчимд	-	Нөхөн сэргээлтийн төлөвлөгөөнд тусгагдсан	-	-		
21.	Тээвэрлэлтийн явцад ургамлан нөмрөг талхлагдах, ургах чадвараа алдах	Уурхайн автозамуудыг дулааны улиралд болон тоос ихээр босох үед усалгаа хийж чийгшүүлэх, олон салаа зам гаргахгүй байх	Төслийн талбайн ойр орчимд	-	-	-	-	Ашиглалтын хугацаанд	

22.		Ажилчдад биологийн олон янз байдал, тэдгээрийг хамгаалах талаар мэдээлэл өгч сургалт явуулах	Уурхайн ажилтнууд	-	-	-	-	Жилд 1 удаа	Байгаль орчныг хамгаалах тухай хууль
Амьтны аймаг									
23.	Хөрсөнд үүрлэдэг жижиг хөхтөн амьтад, бусад шавж зэрэг амьд биетүүдийн амьдрах орчин алдагдах, сүйтгэгдэх	Уурхайн эдэлбэрээс бусад эрүүл талбайд газар ухаж амьтдын үүр нүх сүйтгэхгүй байх	Уурхайн ойр орчимд	-	-	-	-	Үйл ажиллагааны туршид	Биологийн хүрээлэнгийн батласан аргазүй
24.	Хог хаягдлыг/хоолны/ эмх замбараагүй хаяснаас болж зарим махчин амьтад идэх, амьтдын амьдрах орчин доройтох, бохирдох	Хог хаягдлыг ангилан ялгаж, тогтмол хугацаанд зайлуулах, хогийн цэгийг халдваргүйжүүлж байх	Уурхайн ойр орчимд	-	-	-	-	Үйл ажиллагааны туршид	
Нийт зардал							1000.0		

ЗУРГАА. НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Хүснэгт 9. Нөхөн сэргээлтийн төлөвлөгөө

№	Нөхөн сэргээлтийн зорилт	Нөхөн сэргээлтийн арга хэмжээ	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэгжийн зардал, мян.төг	Нийт зардал, мян.төг	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах эрхзүйн баримт бичиг
	1	2	3	4	5	6	7	8
1.	Техникийн нөхөн сэргээлт	эвдрэлд орсон зам талбайг тэгшлэн, овоолгын хажууг орчны байдалтай нь зохицуулан хэлбэржүүлсэний дараа ургамалжуулах, хөрсний бэхжилтийг блок дуусах үед хийхтэй холбогдуулан урьдчилсан бэлтгэл хийх	-	-	-	-	2023 он	Ашигт малтмалын тухай хууль, Байгаль хамгаалах тухай хууль, БОНХАЖЯ-ны сайдын А-138-р тушаал, Уул уурхайн үйл ажиллагааны улмаас эвдрэлд орсон газарт техникийн болон биологийн нөхөн сэргээлт хийх аргачлал, 5915:2008 Газар шорооны ажлын үед шимт хөрс хуулалт, хадгалалт MNS 5916:2008 MNS 5917-2008 MNS 5918-2008
2.	Биологийн нөхөн сэргээлт	Нөхөн дүүргэлт хийсний дараа шимт хөрсөөр хучна.	-	-	Эхний блок дуусах 2024-2026 онуудад 1.5 га биологийн нөхөн сэргээлт хийнэ.		2024-	
Нийт зардал						200.0		

Техникийн нөхөн сэргээлт: Ордын ашиглалтын явцад эвдэрсэн газрын гадарга, хэвлий, байгалийн унаган төрхөө алдсан газрыг булж тэгшлэх, аюулгүй болгох(нурах, гулсах г.м.), хэлбэржүүлэх, суваг шуудуу татаж хөрсний эвдрэл үүсэхээс хамгаалах, тэгшиж хэлбэржүүлсэн талбайг шимт хөрсөөр хучихад техникийн нөхөн сэргээлтийн гол зорилго оршино.

Мөн техникийн нөхөн сэргээлтэнд ашиглалтад өртөх шимт хөрсийг тусад нь хуулж хадгалах гэх мэт нөхөн сэргээлтийн бэлтгэл ажлууд, газрын гадарга болон уурхайг үер уснаас хамгаалах, уурхайд хүн, мал, амьтан, машин техник орж осолдохоос хамгаалах далан, шуудуу хийгдэнэ.

Уурхайн техникийн нөхөн сэргээлтээр дараах арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлнэ. Үүнд:

Үржил шимт өнгөн хөрсийг хуулах, тээвэрлэх ажил: Уурхайн ашиглалт болон овоолгын талбайд өртөх шимт хөрсийг хамгийн түрүүнд хуулж авна.

Үржил шимт өнгөн хөрсийг дунджаар 20-30 см зузаантайгаар хуулж биологийн нөхөн сэргээлт хийх талбайд буулгах эсвэл ажлын фронтын өрнөлтийн бус талд түр овоолго байгуулна. Шимт хөрсний түр овоолгын өндөр 2 м-ээс илүүгүй байх бөгөөд гадаргуу дээгүүр автосамосвал, бульдозер гэх мэт хүнд даацын тоног төхөөрөмж явахгүй байх шаардлагыг баримтлана.

Энэ ажлыг уулын инженер, маркшейдрүүд жил бүрийн уулын ажлын төлөвлөгөөнд бодитойгоор тусгах шаардлагатай ба шимт хөрсийг зөвхөн дулааны улиралд буюу 4, 5, 6 сард хуулна.

Техникийн нөхөн сэргээлтийг дараах стандартуудын дагуу хийнэ. Үүнд:

- ☆ Эвдэрсэн газрын нөхөн сэргээлт. Нэр томъёо, тодорхойлолт MNS 5914:2008
- ☆ Уул ордын үйлдвэрлэлийн үйл ажиллагаагаар эвдэрсэн газрын ангилал MNS 5915:2008
- ☆ Газар шорооны ажлын үед шимт хөрс хуулалт, хадгалалт MNS 5916:2008

